

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 13 ДУГААР ХУРАЛ**

2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 15 цаг 45 минутад эхэлж, 20 цаг 40 хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 4 цаг 55 минут хуралдав.

д д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн 2015 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай	1.Аймгийн 2015 оны төсвийн нэмэлт өөрчлөлтийг дэмжиж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатарт үүрэг болгов.
2.	Аймгийн 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл, 2016 оны төсвийн тухай	<p>1.Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 20,0 сая төгрөгөөр</p> <p>2. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 20,0 сая төгрөгөөр тус тус орлогын нэмэгдүүлэхээр</p> <p>3. Биеийн тамир, спортын газрын өөрийн орлогыг 30,0 сая төгрөг болгож, зөрүүг нэмэгдүүлж, нэмэгдүүлсэн хэмжээгээр биеийн тамирын уралдаан тэмцээний зардалд зарцуулахаар</p> <p>4.Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Өмчийн албаны хөрөнгийн тооллого хийхэд 5,0 сая төгрөгөөр зарлагыг нэмэгдүүлэхээр</p> <p>5.Цаг агаарт зориудаар нөлөөж, хур тунадас нэмэгдүүлэхэд 25,0 төгрөгөөр зарлагыг нэмэгдүүлэхээр</p> <p>6.Ерөнхий боловсролын сургуулийн халаалтын хугацааг наашлуулж үүнээс гарах хэмнэлт 80,0 сая төгрөгийг хичээлийн хэрэглэгдхүүний зардалд хуваарилахаар</p> <p>7.Шинээр байгуулагдсан 13 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааг хэвийн явуулахад зайлшгүй шаардлагатай 12 нэр төрөл бүхий 17,124,700 төгрөгийн тоног төхөөрөмжийг Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэхээр тус тус шийдвэрлэв.</p> <p>8.Аймгийн 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл, 2016 оны төсвийг дэмжиж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатарт үүрэг болгов.</p>

3.	Орон нутгийн татварын хувь хэмжээнд өөрчлөлт оруулах тухай	Орон нутгийн татварын хувь хэмжээнд оруулах өөрчлөлтийг дэмжиж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатарт үүрэг болгов.
4	Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тухай	Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн талаар хэлэлцэх явцад гарсан саналуудыг тусгаж, дахин биелэлтийн хувийг тооцож, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Батмөнхөд үүрэг болгов.
5	Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2015 оны хэрэгжилтийн дүн, 2016 оны зорилтын тухай илтгэлийн төсөл	Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2015 оны хэрэгжилтийн дүн, 2016 оны зорилтын тухай илтгэлийн төслийг дэмжив.
6	Бусад асуудал	Аймгийн Цагдаагийн газрыг Цагдаагийн байгууллага байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Төрийн дээд шагнал “Цэргийн гавъяаны одон”-гоор шагнуулахаар дэмжиж, санал авч уламжлахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Батмөнхөд үүрэг болгов.

### АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 14 ДУГААР ХУРАЛ**

2015 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 14 цаг 50 минутад эхэлж, 16 цаг 55 хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 2 цаг 05 минут хуралдав.

Д Д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тухай	1.Улаан богочын 1,8 га газрыг худалдаа үйлдвэрлэлийн зорулалтаар зам дагуулан байхаар 5 га болгон нэмэгдүүлэхээр 2.Халамжийн байрны ард талд төлөвлөсөн грашын газрыг төлөвлөлтөөс хасахаар 3.5 дугаар хавсралтын Жаргалант сумын Цамбагарав багийн 2 голын дундах газрыг нийтийн эдэлбэр газрын төлөвлөлтөнд оруулахаар 4.Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн хашааны залгаа 2 айлын хашааны газар эзэмшүүлэх саналыг хасаж, хажуу талын зөвшөөрөлтэй газрыг хүчингүй болгохоор санал тус тус гарч, аймгийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг дэмжиж, төлөвлөгөөний төсөл хэлэлцэх явцад гарсан санал, өөрчлөлтийг тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямтулгад үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР